

## ФОРУМЫН ХААЛТЫН ҮГ

СУНДУЙН БАТБОЛД  
Нийслэлийн Засаг дарга бөгөөд  
Улаанбаатар хотын захирагч

Эрхэм хүндэт хотын дарга нараа, хүндэт зочдоо,

“Нүүрстөрөгч багатай хотуудын хөгжил: Агаарын чанарыг сайжруулж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах нь” сэдвийн дор зохиогдож буй 3 дахь удаагийн Зүүн хойд Азийн хотын дарга нарын форум энд хүрээд өндөрлөж байна.

Байгалийн нөөц бага ашиглах, цэвэр технологи шингэсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээнд л ирээдүй байгааг нотлон харуулсан, нүүрстөрөгч багатай хөгжил рүү хурдацтай шилжиж буй хотууддаа баяр хүргэе. Бас шилжихээр бэлтгэж буй хотууддаа амжилт хүсье.

Хөгжлийн түвшин, хүн амын тоо, эдийн засгийн боломж нь харилцан адилгүй боловч бүс нутгийн хотууд маань хил хязгаараас үл хамаарах байгаль орчны тулгамдсан асуудлыг хамтдаа ярьж, шийдлийг нь цугтаа хэлэлцэж байгаа нь энэхүү форумын ач холбогдлыг тодруулж байгаа хэрэг болов уу.

Хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих шилжилт зайлшгүй бөгөөд энэхүү шилжилт нь хотуудын манлайлал, технологийн хүчээр эдийн засгийн илүү өргөн боломж, нийгмийн дэвшлийг авчрах нь дамжиггүй гэдгийг бид бүхэн үгээрээ, үйл хэргээрээ харууллаа.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэгдэн баталгаажсан баримт бичгээр Улаанбаатар хотын санаачилсан форумыг бүс нутгийн хотуудын хамтын ажиллагааны байнгын механизм болгож өгсөн хотуудын дарга, төлөөлөгчиддөө баярлалаа.

2020 оны Зүүн хойд Азийн хотын дарга нарын форумыг зохион байгуулах Сөүл хотынхондоо амжилт хүсье.

“No one left behind” буюу “Хөгжлөөс хэн ч хоцрох ёсгүй” гэсэн Тогтвортой хөгжлийн зорилтын уриагаар үгээ өндөрлөө. Та бүхэндээ сайн сайхныг хүсэн ерөөе.